



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/27/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер Б.Долгорсүрэн
Утас: 260512 Цахим хаяг: Dolgorsuren.B@audit.mn
Аудитор Ж.Мөнхтуул
Утас: 261885 Цахим хаяг: munkhtuulj@audit.gov.mn
Пийк ОМ Аудит ХХК-ийн захирал: Б.Жаргалсайхан
Утас: 99862066 Цахим хаяг: peakomauditllc@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	15
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	17
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	17
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	17
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	22
4.1 Ерөнхий зүйл.....	22
4.2 Материаллаг байдал.....	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	22
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	22
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	23
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	24
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	25
5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа	25
5.1.1 Зөвлөмж	25
5.2 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн санхүүгийн зөрчил	25
5.2.1 Албан шаардлага	26
5.2.2 Зөвлөмж.....	26
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	28

Товчилсон үгийн жагсаалт

Товчилсон үг	Тайлбар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДЭХ	Дулааны эрчим хүч
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУИХ	Монгол Улсын Их Хурал
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ОХУ	Оросын холбооны улс
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
ТЗЭ	Тусгай зөвшөөрөл эзэмшигч
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын их хурал
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026 03.16 № 06/713
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Ослоос шалтгаалан устсан 28,072.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг эрх бүхий байгууллагын шийдвэр эцэслэн гараагүйгээс данснаас хасаагүй;
- Тайлант онд 118.7 сая төгрөгийн авлага, 32.5 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.6, 20.2, 20.2.6 дахь заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, оршин байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор төрийн өмчит компаниудыг удирдлага менежментээр хангах чиг үүрэгтэй Эрчист Монгол ХХК-ийг байгуулж, түүний харьяанд ажиллах компаниудыг нэрсийг баталсан байна.

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийн төлөөллийн 66.0 хувийг Эрчим хүчний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, 34.0 хувийг “Эрчист Монгол” ХХК тус тус хэрэгжүүлэхээр баталсан байна.

Засгийн газрын Онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн 2025 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн Б/69 дүгээр тушаалаар осолтой холбоотой уртасгасан цагаар ажилласан гэсэн тайлбартайгаар нийт ажилчдад 586.6 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Дулааны эрчим хүчийг үйлдвэрлэх өөрийн дундаж өртөг 2025 онд 28,151.27 төгрөг боловч худалдах дундаж үнэ 4,578.03 төгрөгөөр борлуулсан нь нэгжээс 23,573.24 төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Дулааны эрчим хүчний тариф өртгөөсөө 6.1 дахин доогуур байгаа нь алдагдалтай ажиллах, мөнгөн урсгалын дутагдалд оруулах гол нөхцөлийг бүрдүүлж байна.

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн турбин зааланд томоохон гэмтэл гарсантай холбоотойгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 02 дугаар тэмдэглэлээр өндөр даралтын станцын галд өртсөн барилга, 9 дүгээр турбогенератор болон туслах тоног төхөөрөмжүүдийг буулгах, данс бүртгэлээс хасах асуудлыг хэлэлцэж, эрх бүхий байгууллагын шийдвэр гартал эвдэрсэн хөрөнгүүдийг агуулахад хадгалах талаар хэлэлцэж шийдвэр гаргасан байна.

Бусад асуудал

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК нь жилд 1.1 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүч, 2.6 сая Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэдэг ба Төвийн бүсийн эрчим хүчний системийн цахилгааны хэрэглээний 14.0 хувийг, Улаанбаатар хотын дулаан хангамжийн 31.0 хувийг, үйлдвэрийн технологийн уурын хэрэглээний 47.0 орчим хувийг ханган ажиллаж байгаа ба үндсэн тоноглолыг 30 жил ашиглах хугацаатай ч дунд даралтын станц 57 дах жилдээ ажиллаж байна. Үүнтэй холбоотойгоор өндөр даралтын станцыг баруун тийш өргөтгөж 1х50МВт-ын турбин, 1х300тн/ц-ийн зуух суурилуулах, дунд даралтын станцыг буулгаж суурин дээр нь шинээр 2х125МВт-ын турбин, 2х600тн/ц-ийн зуух суурилуулах төслийн ажлыг 2022 оноос эхлэн хэрэгжүүлж байна.

Тайлант онд Оросын Холбооны Улсын Интер РАО-Экспорт компанитай Станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг төсөл боловсруулах гэрээ байгуулах хэлцэл хийгдэж байна.

Дээрх асуудал нь аудитын дүгнэлтэд шууд нөлөөлөхгүй боловч цаашид тайлангийн хэрэглэгчид зайлшгүй анхаарах шаардлагатай.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,146,728,234.22	638,677,641.28
1.1.02	Дансны авлага	5,258,999,385.55	20,491,386,028.94
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	545,637,582.13	765,152,520.81
1.1.04	Бусад авлага	119,338,319.06	35,647,851.58
1.1.05	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.06	Бараа материал	19,991,293,060.66	17,000,911,019.10
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	557,787,040.78	728,915,841.98
1.1.08	Бусад эргэлтийн хөрөнгө	204,765,158.10	-
1.1.09	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эрг-н бус хөрөнгө	-	-
1.1.10	Бусад	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	27,824,548,780.50	39,660,690,903.69
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.01	Үндсэн хөрөнгө	223,601,845,883.97	279,373,111,704.12
1.2.02	Биет бус хөрөнгө	42,829,694,950.53	73,683,243,415.84
1.2.03	Биологийн хөрөнгө	-	-
1.2.04	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.05	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.06	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.07	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө	949,001,776.48	778,778,068.46
1.2.09	Дуусаагүй барилга	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	267,380,542,610.98	353,835,133,188.42
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	295,205,091,391.48	393,495,824,092.11
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.01	Дансны өглөг	8,127,430,446.82	11,768,086,558.65
2.1.1.02	Цалингийн өглөг	-	4,764,352.08
2.1.1.03	Татварын өр	1,235,574,654.83	1,327,158,056.59
2.1.1.04	НДШ - ийн өглөг	-	176,722,397.04
2.1.1.05	Богино хугацаат зээл	2,264,700,851.73	2,165,600,852.72
2.1.1.06	Хүүний өглөг	180,672,410.33	173,625,019.93
2.1.1.07	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	36,468,205.77	3,703,510,568.90
2.1.1.09	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	342,339,962.66	265,364,676.90
2.1.1.11	Борлуулах бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.12	Бусад	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	12,187,186,532.14	19,584,832,482.81

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.01	Урт хугацаат зээл	15,516,325,177.18	13,350,724,324.46
2.1.2.02	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр	885,825,635.85	885,825,635.85
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	1,259,194,398.71	893,808,997.40
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	17,661,345,211.74	15,130,358,957.71
2.2	Өр төлбөрийн нийт дүн	29,848,531,743.88	34,715,191,440.52
2.3	Эздийн өмч	-	-
2.3.01	Өмч: - төрийн	99,362,782,973.56	99,362,782,973.56
2.3.02	- хувийн	-	-
2.3.03	- хувьцаат	-	-
2.3.04	Халаасны хувьцаа	-	-
2.3.05	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	157,199,785,506.94	222,190,585,364.19
2.3.07	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	42,708,896,070.00	73,210,542,470.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(33,914,904,902.90)	(35,983,278,156.16)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	(2,601,777,565.35)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(33,914,904,902.90)	(33,381,500,590.81)
2.3.11	Эздийн өмчийн дүн	265,356,559,647.60	358,780,632,651.59
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	295,205,091,391.48	393,495,824,092.11

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	173,664,317,640.97	209,452,583,741.80
2	Борлуулалтын өртөг	168,454,735,849.24	190,454,515,710.11
3	Нийт ашиг(алдагдал)	5,209,581,791.73	18,998,068,031.69
4	Түрээсийн орлого	79,949,357.32	73,575,087.92
5	Хүүний орлого	20,595,102.08	26,746,567.29
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	13,757,077,173.78	964,812,059.93
8.1	Орлогын дүн	13,857,621,633.18	1,065,133,715.14
9	Борлуулалт, маркетингийн зардал	369,753,736.97	478,379,559.84
10	Ерөнхий ба удирдлагын зардал	12,554,877,624.61	14,874,102,265.59
11	Санхүүгийн зардал	799,093,448.38	753,552,645.75
12	Бусад зардал	4,365,081,550.78	6,555,892,982.17
12.1	Зардлын дүн	18,088,806,360.74	22,661,927,453.35
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(298,490.04)	(377,202.09)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
17.1	Олз, гарзын дүн	(298,490.04)	(377,202.09)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	978,098,574.13	(2,599,102,908.61)
19	Орлогын татварын зардал	102,315,044.52	2,674,656.74
20	Татварын дараах ашиг (алдагдал)	875,783,529.61	(2,601,777,565.35)
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	875,783,529.61	(2,601,777,565.35)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	99,362,782,973.56	157,760,921,987.30	39,454,300,000.00	(35,351,824,912.87)	261,226,180,047.99
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	561,136,480.36	561,136,480.36
Залруулсан үлдэгдэл	99,362,782,973.56	157,760,921,987.30	39,454,300,000.00	(34,790,688,432.51)	261,787,316,528.35
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	875,783,529.61	875,783,529.61
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	3,254,596,070.00	-	3,254,596,070.00
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(561,136,480.36)	-	-	(561,136,480.36)
2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	99,362,782,973.56	157,199,785,506.94	42,708,896,070.00	(33,914,904,902.90)	265,356,559,647.60
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	533,404,312.09	533,404,312.09
Залруулсан үлдэгдэл	99,362,782,973.56	157,199,785,506.94	42,708,896,070.00	(33,381,500,590.81)	265,889,963,959.69
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(2,601,777,565.35)	(2,601,777,565.35)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	30,501,646,400.00	-	30,501,646,400.00
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	64,990,799,857.25	-	-	64,990,799,857.25
2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	99,362,782,973.56	222,190,585,364.19	73,210,542,470.00	(35,983,278,156.16)	358,780,632,651.59

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	184,970,512,464.27	194,289,704,354.48
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	169,931,246,935.00	193,394,492,298.55
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	235,215,726.00	271,919,402.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	14,316,861,000.00	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	487,188,803.27	623,292,653.93
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	171,310,337,002.71	172,648,444,524.58
1.2.1	Ажиллагчдад төлсөн	41,061,524,023.66	42,584,197,057.87
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	12,526,025,056.00	13,618,606,537.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	84,867,586,353.34	87,846,087,053.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	2,643,787,185.63	3,381,274,870.57
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	15,148,862,439.83	10,943,579,099.38
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	9,204,430.68	296,125,684.52
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	11,623,316,965.85	9,069,591,908.69
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	5,700,000.00	57,820,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	3,424,330,547.72	4,851,162,313.55
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,660,175,461.56	21,641,259,829.90
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	20,595,102.08	26,746,567.29
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	20,595,102.08	26,746,567.29
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.8	Бусад	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	14,024,367,939.59	7,547,139,342.44
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	14,024,367,939.59	17,547,139,342.44
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.2.6	Бусад	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	14,003,772,837.51	(17,520,392,775.15)

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Бусад	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	967,625,621.75	4,628,917,647.69
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	967,625,621.75	4,628,917,647.69
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5	Бусад	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(967,625,621.75)	(4,628,917,647.69)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,311,222,997.70)	(508,050,592.94)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,457,951,231.92	1,146,728,234.22
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,146,728,234.22	638,677,641.28

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Хэмжих нэгж	Өмнөх оны гүйцэтгэл	2025 он		Өөрчлөлт /өссөн +, буурсан -/	
					Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Боловсруулсан:	Цахилгаан эрчим хүч	мян.кВтц	1,114,965.7	880,119.6	879,943.2	(176.4)	(0.0)
	ДХЦЭХ	хувиар	хувь	16.9	19.8	19.7	(0.1)	(0.3)
		биетээр	мян.кВтц	188,592.8	174,215.5	173,633.1	(582.5)	(0.3)
	Эрчим хүчний түгээлт	ЦЭХ	мян.кВтц	926,372.9	705,904.1	706,310.1	406.1	0.1
		ДЭХ	Гкал	2,579,469.0	2,667,100.0	2,667,281.1	181.1	0.0
	Үнийн дүнгээр	ЦЭХ	мян.төг	154,513,259.6	197,156,308.7	197,241,702.2	85,393.6	0.0
ДЭХ		мян.төг	19,151,058.1	11,932,804.4	12,210,881.5	278,077.1	2.3	
2	Нийт орлого		мян.төг	187,521,939.3	209,920,157.7	210,517,723.6	597,565.9	0.3
	Үүнээс:	Цэвэр борлуулалт	мян.төг	173,664,317.6	209,089,113.1	209,452,583.7	363,470.7	0.2
		Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	13,857,621.6	831,044.7	1,065,139.9	234,095.2	28.2
3	Нийт зардал		мян.төг	186,543,840.7	215,665,291.9	213,116,826.5	(2,548,465.4)	(1.2)
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	мян.төг	185,664,409.1	212,892,567.1	210,398,022.1	(2,494,545.0)	(1.2)
		Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	879,431.6	2,772,724.7	2,718,804.4	(53,920.4)	(1.9)
		Элэгдлийн зардал	мян.төг	21,705,878.0	32,001,989.7	31,862,588.5	(139,401.2)	(0.4)
4	Татварын өмнөх ашиг /алдагдал -/		мян.төг	978,098.6	(5,745,134.2)	(2,599,102.9)	3,146,031.2	(54.8)
5	Цэвэр ашиг /алдагдал -/		мян.төг	875,783.5	(5,745,134.2)	(2,601,777.6)	3,143,356.6	(54.7)
6	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал		мян.төг	1.1	1.0	1.0	(0.0)	(1.3)
7	Нийт авлага		мян.төг	5,923,975.3	26,294,225.1	21,292,186.4	(5,002,038.7)	(19.0)
	Үүнээс:	Эрчим хүчний	мян.төг	5,258,999.4	25,694,225.1	20,491,386.0	(5,202,839.0)	(20.2)
		Бусад	мян.төг	664,975.9	600,000.0	800,800.4	200,800.4	33.5
8	Нийт өглөг		мян.төг	29,848,531.7	41,824,126.3	34,715,191.4	(7,108,934.9)	(17.0)
	Богино хугацаат өр төлбөр		мян.төг	12,187,186.5	26,693,573.4	19,584,832.5	(7,108,740.9)	(26.6)
	Урт хугацаат өр төлбөр		мян.төг	17,661,345.2	15,130,552.9	15,130,359.0	(194.0)	(0.0)
9	Нийт ажиллагсдын тоо		хүн	975.5	972.0	966.0	(6.0)	(0.6)
10	Нийт цалингийн сан		мян.төг	48,279,361.6	53,996,603.5	53,968,554.2	(28,049.3)	(0.1)
11	Нэг ажиллагчийн дундаж цалин /ЖҮД-тэй/		төг	4,124,326.1	4,629,338.4	4,655,672.4	26,333.9	0.6
12	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	цахилгаан	гр/кВтц	320.3	350.0	347.8	(2.2)	(0.6)
		дулаан	кг/Гкал	176.0	176.8	176.4	(0.4)	(0.2)
13	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт		мян.төг	22,069,834.7	96,078,412.7	38,264,826.5	(57,813,586.2)	(60.2)
	Үндсэн тоноглолын их засвар		мян.төг	12,022,185.0	10,858,189.1	10,727,483.0	(130,706.2)	(1.2)

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Туслах тоноглолын их засвар	мян.төг	4,626,497.0	5,352,525.1	5,018,324.7	(334,200.4)	(6.2)
Барилгын их засвар	мян.төг	746,746.6	7,896,219.5	7,044,040.8	(852,178.7)	(10.8)
ТЗБАХэмжээний дүн	мян.төг	3,383,093.7	59,315,367.2	3,252,833.7	(56,062,533.5)	(94.5)
Хөрөнгө оруулалтын дүн	мян.төг	1,291,312.4	12,656,111.8	12,222,144.4	(433,967.4)	(3.4)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн суурь 1966 онд тавигдаж, 1968 онд анхны зуух ашиглалтад орсноор нийслэлийн албан байгууллага, орон сууцыг дулааны эрчим хүчээр хангаж эхэлжээ. Үүнээс хойш 1968-1975 онд 48 мВт-ын дунд даралтын станц, 1976-1981 онд 100мВт-ын өндөр даралтын станц ашиглалтад оруулж, 2013-2014 онд өндөр даралтын станцыг 50мВт-аар өргөтгөснөөр нийт суурилагдсан хүчин чадал 198 мВт болсон. Тус станц жилд 1.1 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүч, 2.6 сая Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэдэг ба Төвийн бүсийн эрчим хүчний системийн цахилгааны хэрэглээний 14.0 хувийг, Улаанбаатар хотын дулаан хангамжийн 31.0 хувийг, үйлдвэрийн технологийн уурын хэрэглээний 47.0 орчим хувийг ханган ажиллаж байна.

Тус станцын дунд даралтын станцын үндсэн тоноглолын насжилт дууссан, үндсэн тоноглол нь металлын бүтцийн өөрчлөлтөд орсон, барилга байгууламжийн насжилт өндөр болсон тул цаашид аюулгүй найдвартай ажиллагааг хангах боломжгүй болсноос шалтгаалан 2022 оноос эхлэн тус станцыг шинэчлэх, өргөтгөх төслийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Үүнд:

- 1-р шат: Өндөр даралтын станцыг баруун тийш өргөтгөж 1х50мВт-ын турбин, 1х300тн/ц-ийн зуух суурилуулах;
- 2-р шат: Дунд даралтын станцыг буулгаж суурин дээр нь шинээр 2х125мВт-ын турбин, 2х600тн/ц-ийн зуух суурилуулах.

Төслийн ажлын явц дараах явцтай байна. Үүнд:

- Интер РАО Экспорт компани төслийн ТЭЗҮ-ийг 2022 оны 8 дүгээр сарын 29-ний өдөр хүлээлгэн өгсөн;
- “Зураг төсөл боловсруулж, инженерийн судалгаа хийх” Засгийн газар хооронд байгуулах хэлэлцээрт 2024 оны 9 дүгээр сарын 03-ны өдөр Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, ОХУ-ын Эрчим хүчний сайд С.Е.Цивилев нар гарын үсэг зурсан;
- Станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг төсөл боловсруулах тухай Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээрийг 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр УИХ-аар соёрхон баталсан;
- ОХУ-ын Интер РАО-Экспорт компанитай Станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг төсөл боловсруулах гэрээ байгуулах хэлцэл хийсэн.

Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд ТӨХК гэсэн статустай бөгөөд нэг бүр нь 100.00 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 993,627,829 ширхэг энгийн хувьцаатай, өмчийг 100.0 хувь төр, үүнээс 66.0 хувийн төлөөллийг Эрчим хүчний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, 34.0 хувийг Эрчист монгол ХХК тус тус хэрэгжүүлэхээр байна.

Засгийн газрын “Эрчист Монгол ХХК байгуулах, давхардсан чиг үүргийг бууруулах тухай” 2025 оны 04 дүгээр тогтоолоор Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийг Эрчист Монгол ХХК-ийн харьяанд ажиллуулахаар тогтоож, харьяа компанийн дүрэмд зохих өөрчлөлт оруулах арга хэмжээг зохион байгуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад даалгасан байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Дулааны гуравдугаар цахилгаан станц төрийн өмчит хувьцаат компанийн дүрэм”-д 2025 оны 06 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон байна.

Дүрэмд компанийн үндсэн зорилтыг “Тодорхой үйлчилгээ явуулах нутаг дэвсгэртээ хэрэглэгчийг цахилгаан, дулааны эрчим хүчээр тасралтгүй, найдвартай бүрэн хангах замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг ханган ажиллахад оршино” гэж тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны үндсэн чиглэл нь цахилгаан, дулаан үйлдвэрлэх, зохицуулалттай хангах, түгээх үйлдвэрлэл эрхэлж үйлчилгээ үзүүлнэ.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Газрын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох УИХ, Засгийн газрын тогтоол, компанийн удирдлагаас баталсан дүрэм, журмуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөл орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Зөрчлийн тухай хууль;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Дулааны гуравдугаар цахилгаан станц төрийн өмчит хувьцаат компанийн дүрэм”;
- Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан 2024-2025 онд хэрэгжүүлэх хамтын гэрээ;
- Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн ажилтнуудад сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох журам.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд үр нөлөөтэй гэж үзсэн.

Тус компанийн Хяналтын хэлтэс нь дарга, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер, Хэмжил зүйч инженер, техник хяналтын инженер, техник ашиглалтын байцаагч инженер зэрэг 23 орон тоотойгоор, гүйцэтгэх захирлын 2024 оны А/234 дугаар тушаалаар баталсан Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн үйл ажиллагаанд дотоод хяналт зохион байгуулах журам"-ыг мөрдлөг болгон ажилладаг.

Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн тайлант онд нийт 17 ажил хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулж, 95.0 хувь хэрэгжсэн гэж тайлагнасан байна. Дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал:

- Компанийн эд хөрөнгийн тооллого явуулах үйл ажиллагаанд хяналт тавих, үл хөдлөх эд хөрөнгийн талаар авах арга хэмжээний талаар тухай бүр өмч хамгаалах комисс, гүйцэтгэх захиралд зөвлөмж хүргүүлсэн;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж, улирал бүр мөнгөн гүйлгээний зарцуулалтад хяналт тавьсан;
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийж, сар бүр мэдээллийг цаг хугацаанд нь байршуулахад хяналт хэрэгжүүлсэн;
- Худалдан авах ажиллагааг зохион байгуулж буй үйл явц, тендер шалгаруулалт, гэрээ байгуулах үйл ажиллагаа, гэрээний хэрэгжилт, бараа нийлүүлэлтийн байдалд хяналт шалгалт хийж 11 зөвлөмж өгсөн;
- Салбар хэлтсүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 7 салбар нэгжийн тулгамдаж буй асуудлыг нэгтгэх, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг дагаж мөрдүүлэх зэрэг арга хэмжээг авсан гэх мэт.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 07 дугаар тогтоолоор Дотоод аудиторын үйл ажиллагааны журам, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны үйл ажиллагааны журам"-ыг баталсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх дотоод аудитор тайлант онд 15 ажил төлөвлөж, батлуулсан байна. Төлөвлөгөөт ажлын хүрээнд 13 ажил, төлөвлөгөөт бусаар 2 ажлыг гүйцэтгэн 2025 оны ажлын тайлангаа тайлагнаж, төлөвлөгөөний биелэлт 100.0 хувьтай байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд Гүйцэтгэх захирлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/118 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө, өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 98,290.7 сая төгрөгөөр буюу 33.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,146,728.2	638,677.6	(508,050.6)
Авлага	5,923,975.3	21,292,186.4	15,368,211.1
Урьдчилгаа	557,787.0	728,915.9	171,128.9
Бараа материал	19,991,293.1	17,000,911.0	(2,990,382.1)
Бусад эргэлтийн хөрөнгө	204,765.2		(204,765.2)
Эргэлтийн бус хөрөнгө	267,380,542.6	353,835,133.2	86,454,590.6
Нийт хөрөнгө	295,205,091.4	393,495,824.1	98,290,732.7
Богино хугацаат өр төлбөр	12,187,186.5	19,584,832.5	7,397,646.0
Урт хугацаат өр төлбөр	17,661,345.2	15,130,359.0	(2,530,986.2)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	265,356,559.7	358,780,632.6	93,424,072.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	295,205,091.4	393,495,824.1	98,290,732.7

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч дансад нөлөө бүхий өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд мөнгөн хөрөнгийн урсгал 508.0 сая төгрөгөөр буурч, 6 арилжааны банкны 8 дансаар гүйлгээ хийсэн байна.
- Авлага дансны үлдэгдэл 21,292.2 сая төгрөг болж, өмнөх оноос 15,368.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Диспетчерийн үндэсний төв ТӨХК-аас авах цахилгаан эрчим хүчний борлуулалтын авлага 15,275.1 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Нийт авлагын 96.2 хувь буюу 20,491.4 сая төгрөг нь борлуулалтын авлага, 3.6 хувь буюу 765.1 сая төгрөг нь татварын, 0.2 хувь буюу 35.6 сая төгрөг нь бусад авлага байна.
- Тайлант хугацааны эцэст бараа материалын үлдэгдэл 17,000.9 сая төгрөг болж, өмнөх оноос 2,990.4 сая төгрөгөөр буурсан нь нүүрсний үлдэгдэл оны эхнээс 28.4 тонноор буюу 1,669.3 сая төгрөгөөр, сэлбэг материалын үлдэгдэл 1,656.0 сая төгрөгөөр багассан нь голлон нөлөөлсөн байна.
- Өмнөх онд бусад эргэлтийн хөрөнгийн дансанд 204.8 сая төгрөгийн өртөгтэй БКЗ-220-100 маркийн зуухыг хурдасгасан буцламгай үет шаталтын технологид шилжүүлэх ТЭЗҮ бүртгэлтэй байсныг аудитын зөвлөмжийн дагуу залруулга хийсэн байна.

- Үндсэн хөрөнгө өмнөх оноос 86,454.6 сая төгрөгөөр нэмэгдэж 353,835.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь дараах шалтгаантай байна. Тухайлбал:
 - Хөрөнгийн дахин үнэлгээгээр бодит үнэ цэнэ 63,533.2 сая төгрөгөөр нэмэгдсэн;
 - Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний ажлын гүйцэтгэлээр 19,589.1 сая төгрөгийг капиталжуулсан;
 - Тайлант оны батлагдсан хөрөнгө оруулалтын төсвийн дагуу 2,236.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 2,059.9 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 162.1 сая төгрөгийн компьютер, 91.3 сая төгрөгийн бус бус хөрөнгө, 42.8 сая төгрөгийн тавилга эд хогшил, нийт 4,592.7 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн;
 - ТӨБЗГ-ын 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй болсон 168 нэр төрлийн 4,583.4 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан.
- Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд бэлтгэн нийлүүлэгч байгууллагад төлөх 11,768.1 сая төгрөгийн, татварын 1,503.9 сая төгрөгийн, НББОУС-ын дагуу 2026 онд төлөх зээлийн үндсэн төлбөр болон хойшлогдсон хүүгийн төлбөрт төлөх 2,339.2 сая төгрөгийг богино хугацаат өглөгт шилжүүлэн бүртгэсэн, урьдчилж орсон орлогын 3,703.5 сая төгрөгийн, ажиллагсдын хоолны картын 125.1 сая төгрөгийн, тэтгэвэрт гарсан болон бусад ажилтнуудад өгөх өр төлбөр 145.0 сая төгрөг бүртгэлтэй байна. Бэлтгэн нийлүүлэгч байгууллагад өгөх өр төлбөр өмнөх оноос өссөн нь нүүрсний үнэ нэмэгдсэнээс шалтгаалан Багануур ХК-д төлөх 2,704.5 сая төгрөгийн өглөгтэй гарсантай холбоотой байна.
- Урьдчилж орсон орлогын 98.5 хувь буюу 3,651.1 сая төгрөг нь Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-д өгөх дулааны эрчим хүчний өглөг байна.
- Урт хугацаат зээлийн үлдэгдэлд 1998-2024 онд эрчим хүчийг сэргээн засварлах, дулааны үр ашгийг дээшлүүлэх, эрчим хүчийг хэмнэх зорилгоор хэрэгжүүлсэн 7 төсөл, хөтөлбөрийн нийт 13,350.7 сая төгрөгийн үлдэгдэл бүртгэлтэй байна. Үүнд:
 - Азийн хөгжлийн банкны 3,546.7 сая төгрөгийн зээл,
 - Нордикийн хөгжлийн сангийн 591.1 сая төгрөгийн зээл,
 - Дулааны үр ашгийн төслийн 1,838.1 сая төгрөгийн зээл,
 - Эрчим хүчний хэмнэлтийн төслийн 183.6 сая төгрөгийн зээл,
 - Эрчим хүчний хөтөлбөр-1 төслийн 183.2 сая төгрөгийн зээл,
 - Эрчим хүчний төслийн 33.7 сая төгрөгийн зээл,
 - Улаанбаатар хотын дулаан хангамжийг нэмэгдүүлэх төслийн 6,974.3 сая төгрөгийн зээл байна.
- Бусад урт хугацаат өр төлбөр дансанд 2014-2017 онд Чех Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Чехийн Хөгжлийн агентлаг, ДЦС-3 ТӨХК-ийн хамтран хэрэгжүүлсэн Түлш дамжуулах цехийн тоноглолын удирдлага, хяналтыг шинэчлэх зорилгоор үүссэн 514.8 сая төгрөгийн хойшлогдсон орлого бүртгэлтэй байна.
- Цэвэр хөрөнгө өмч өмнөх оноос 93,424.1 сая төгрөгөөр өссөн нь Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 15-ний өдрийн А/45 дугаар захирамжийн дагуу 1269 м.кв-аар газрын хэмжээг нэмэгдүүлсэн, ТӨБЗГ-ын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А1/628 дугаар албан бичгийн дагуу газар эзэмших эрхийн үнэлгээг шинэчлэх тогтоох ажлыг Мастер үнэлгээ ХХК-аар гүйцэтгүүлж, 424,337 м.кв газрыг “Биет бус хөрөнгө газар эзэмших эрх” дансанд бүртгэж, газрын үнэлгээ 30,501.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Судалгааны үр дүн: Тус станцын программ хангамжийн дансанд бүртгэлтэй 2006-2025 онд худалдан авч, ашиглаж байгаа Ажиллагсдын цагийн бүртгэл, албан хэрэг хөтлөлт, санхүүгийн программ, техник эдийн засгийн үзүүлэлт гаргах, төсвийн тооцоолол, нүүрсстэй вагоны бодит болон цэвэр жингийн тооцоолол, компьютерын үйлдлийн системийн лиценз болон дулааны цахилгаан станцын инженерийн зориулалттай 45 нэр төрлийн, нийт 798.8 сая төгрөгийн өртөгтэй программ хангамжууд байна. Тайлант онд программ хангамж хөгжүүлэхтэй холбоотой зардал гараагүй байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3¹-т заасны дагуу компани нь санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 28 дугаар тогтоолоор 2025 оны үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, 3 удаа тодотгосон байна.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /гол нэр төрлөөр/

Тус компани 2025 онд 879.9 сая кВт.ц цахилгаан эрчим хүч боловсруулснаас 706.3 сая кВт.ц цахилгаан эрчим хүч түгээсэн ба цахилгаан эмчим хүчний түгээлт тодотгосон төлөвлөгөөнөөс 406.1 мян кВт.ц-аар нэмэгдэж, өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 220.1 сая кВт.ц-аар буюу 23.8 хувиар буурсан байна. Нийт боловсруулсан цахилгаан эрчим хүчний 19.7 хувь буюу 173.6 сая кВт.ц цахилгаан эрчим хүчийг дотоод хэрэгцээнд зарцуулсан нь төлөвлөснөөс 0.06 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд усаар 2,425.2 мянган Гкал, уураар 242.0 мянган Гкал буюу нийт 2,667.3 мянган Гкал дулааны эрчим хүч түгээсэн нь тодотгосон төлөвлөгөөнөөс 0.2 мян Гкалаар, өмнөх оноос 87.8 мян Гкалаар тус тус нэмэгдсэн байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэл

Тайлант онд нийт 209,920.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 215,665.3 сая төгрөгийн зардал гаргаж, 5,745.1 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, төсөвт 1,457.6 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр 210,517.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 213,133.4 сая төгрөгийн зардал гарган, төсөвт 29,839.1 сая төгрөг төвлөрүүлж, 2,618.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Борлуулалтын орлого төлөвлөснөөс 597.6 сая төгрөгөөр буюу 3.0 хувиар давж биелсэн нь цахилгаан эрчим хүчний болон дулааны эрчим хүчний түгээлтийн тоо хэмжээний өөрчлөлтөөс голлон нөлөөлсөн байна. Тухайлбал:

- Диспетчерийн үндэсний төв ТӨХК-тай тооцох цахилгаан эмчим хүчний түгээлт 335.4 мян.кВтц-аар нэмэгдсэн;
- Станцаас хэрэглэгчдэд шууд түгээсэн цахилгаан эрчим хүчний түгээлт 87.5 мян.кВтц-аар нэмэгдсэн;
- Спот зах зээлээс олсон орлого 34.0 сая төгрөг нэмэгдсэн;
- Уурын бичилтийн хувь 81.5 хувь болж нэмэгдсэн гэх мэт.

Нийт зардлын гүйцэтгэл төлөвлөснөөс 2,531.9 сая төгрөгөөр буюу 2.2 хувиар дутуу гүйцэтгэлтэй гарахад дараах шалтгаанууд голлон нөлөөлсөн байна. Тухайлбал:

- Түлшний зардалд 97,037.3 сая төгрөг зарцуулж төлөвлөснөөс 1,178.6 сая төгрөгөөр хэмнэсэн бөгөөд жишмэл түлшний хувийн зарцуулалт цахилгаанд 2.2 гр/кВтц, дулаанд 0.4 кг/Гкалаар буурснаар 278.0 сая төгрөгөөр, нүүрсний илчлэгчийн нэмэгдлээс 369.8 сая төгрөгөөр, тээврийн зардал 248.2 сая төгрөгөөр, УБТЗ-ын нэмэгдэл хөлс 105.2 сая төгрөгөөр, зуухны хүйтэн галлагаа болон зогсолтын тоо буурснаар мазутын зардал 196.3 сая төгрөг, дизель түлш 8.4 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн;
- Бусад тогтмол зардал 6,406.6 сая төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 719.7 сая төгрөгийг хэмнэсэн нь ус ашиглалтын зардал тоо хэмжээнээс шалтгаалан 62.5 сая төгрөгөөр, трансформаторын алдагдал 35.6 мянган кВт.ц-аар буурснаар цахилгааны зардал 11.6 сая төгрөгөөр, боловсруулсан усны хэмжээнээс шалтгаалан химийн туслах материал 61.8 сая мянган төгрөгөөр, хүнд механизмын шатахууны зардал 84.4 сая төгрөгөөр, сэлбэг хэрэгсэл хангамжийн материал 24.1 сая төгрөгөөр, албан

¹ 20.1.Захирал дараахь эрх, үүрэгтэй:3/үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;

томилолтын зардал 44.5 сая төгрөгөөр, контор хангамжийн зардал 6.3 сая төгрөгөөр, галын аюулаас урьдчилан сэргийлэх зардал нэг орон тоо дутуу ажилласан болон материалын зардлаас шалтгаалан 79.0 сая төгрөгөөр, Эрчист Монгол ТӨХХК-ийн менежментийн үйлчилгээний төлбөр 16.1 сая төгрөгөөр, сургалтын зардал 67.0 сая төгрөгөөр, тэрбум мод тарих хөдөлгөөний хүрээнд тухайн онд гарах мод тарих ажил хойшлогдсоноор байгаль орчны зардал 125.0 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн нь гол нөлөө үзүүлсэн;

- Ажилчдын нийгмийн зардал 5,561.4 сая төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 234.7 сая төгрөг хэмнэсэн нь тэтгэврийн тэтгэмжийн зардал 54.8 сая төгрөгөөр, ажилчдын хоолны хөнгөлөлтийн зардал 24.4 сая төгрөгөөр, ажилчдын урьдчилсан сэргийлэх үзлэг хойшлогдсоноор эмнэлэг эмчилгээний зардал 169.3 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагаанд 210,398.0 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагаанд 2,718.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Борлуулалтын 1.00 төгрөгт 1.02 төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 1.00 төгрөгийг зарцуулсан байна.

Ашиг/алдагдлын талаар

Тайлант онд цахилгаан эрчим хүчний нэгжийн өөрийн өртөг 191.6 төгрөгт хүрч, нэг кВт.ц ЦЭХ-ийг дунджаар 279.3 төгрөгөөр борлуулж, нэгжээс 87.7 төгрөгийн, нийт цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлээс 61,931.0 сая төгрөгийн ашигтай ажилласан.

Дулааны эрчим хүчний нэгжийн өөрийн өртөг гүйцэтгэлээр 28,151.9 төгрөг хүрч, нэг Гкал дулааны эрчим хүчийг дунджаар 4,578.0 төгрөгөөр борлуулсан нь нэгжээс 23,573.9 төгрөгийн, нийт дулааны эрчим хүч үйлдвэрлэлтээс 62,876.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Үндсэн бус үйл ажиллагаанаас 1,653.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан ба энэ нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийгдсэнээр нийт 149 нэр төрлийн хөрөнгийн бодит үнэ цэний бууралтыг гарзаар хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой.

Хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндсэн тоноглолын 6 их засварын ажилд 10,858.2 сая төгрөгийн, туслах тоноглолын 92 ажил 5,353.5 сая төгрөгийн, барилгын засварын 14 ажилд 7,896.2 сая төгрөгийн, техник зохион байгуулалтын хүрээнд хийгдэх 19 ажилд 17,185.3 сая төгрөгийн, бусад хөрөнгө оруулалтын 51 арга хэмжээнд 10,656.1 төгрөгийн, нийт 51,948.4 сая төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс 53.4 хувийн, өөрийн хөрөнгөөр 46.6 хувийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн байна.

Үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараах ажлыг хийхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Дулааны гуравдугаар цахилгаан станцын 50 мВт-ын турбингенератор №9 шинээр суурилуулах 54,545.5 сая төгрөг;
- Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл хэсгийн дээвэр, байрны засварын ажилд 6,363.6 сая төгрөг;
- Дулааны гуравдугаар цахилгаан станцын дулаанжуулалтын тоноглолын өргөтгөл, шинэчлэлийн ажилд 7,737.4 сая төгрөг.

Тайлант хугацаанд үндсэн тоноглолын их засварын ажилд 10,727.5 сая төгрөг, туслах тоноглолын их засварын ажилд 5,018.3 сая төгрөг, барилгын их засварын ажилд 7,044.0 сая төгрөг, ТЗБАХ-ний ажилд 3,252.8 сая төгрөг, хөрөнгө оруулалтаар хийгдэх ажилд 12,222.1 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн. Үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 14,142.3 сая төгрөг, өөрийн хөрөнгө оруулалтаар 24,140.5 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу дараах судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Үүнд:

- Гүйцэтгэх захирлын 2025 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн Б/296 дугаар тушаалаар ажлын унаа, хоолны тарифыг 7.5 мянган төгрөгөөр тогтоож, тайлант хугацаанд 1,520.6 сая төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт олгосон.
- Тайлант онд 3 удаагийн гадаад албан томилолтод 82.2 сая төгрөг зарцуулсан байна. Үүнд:
 - 300 мВТ-ын өргөтгөлийн төслийн ажлын зураг төсөв боловсруулах гэрээний холбогдох заалтуудыг гүйцэтгэгч компанитай тохиролцох;
 - 300 мВТ-ын өргөтгөлийн төслийн ажлын зураг боловсруулах гэрээний хэлэлцүүлэг хийх;
 - Сэргээн босголтын хүрээнд 50мВТ-ын турбины шинэчлэлийн төслийн ажлаар.
- Тухайн жил сургалтын төлөвлөгөөнд 339.6 сая төгрөг төлөвлөснөөс, гүйцэтгэлээр инженер техникийн ажилтнуудын, ХАБЭА-н, ажилчдын, тусгай шаардлагын, ажилтныг хөгжүүлэх үйл ажиллагааны зэрэг мэргэшил дээшлүүлэх болон ажлын байрны шаардлагатай бусад сургалтуудад 272.6 сая төгрөг зарцуулж 66.9 сая төгрөг хэмнэсэн байна.
- Тайлант онд 1004 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 970 орон тоогоор ажилласан байна. Тус станц нь тайлант онд цомхотгол хийгээгүй нийт 32 орон тоо дутуу, цалингийн зардал хэмнэсэн байна.
- Тус станц нь хэвлэл мэдээллийн 7 байгууллагатай 122.8 сая төгрөгийн гэрээ байгуулан ажилласан байна.
- Тайлант онд төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Пийк ОМ Аудит ХХК-ийн ахлах аудитор А.Мөнхцэцэг, аудитор А.Батболд нар гүйцэтгэж, захирал Б.Жаргалсайхан анхан шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, Санхүүгийн аудитын газрын аудитор Ж.Мөнхтуул, аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК нь 2025 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 1/235 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 186,543.8 сая төгрөгийн 1.0 хувь буюу 1,865.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж байгаатай холбоотойгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Цахилгаан хөдөлгүүр, насос, трансформаторыг шинэчлэх, уурын шугам, усны шугам хоолой болон барилгын дулаан алдагдал бууруулах, тоолуур шинэчлэх, давтамж хувиргуур суурилуулах болон зуухны шаталтын технологийн өөрчлөлт хийх зэрэг олон талт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсний үр дүнд станцын үндсэн болон туслах тоноглолуудын тасралтгүй, найдвартай ажиллах нөхцөл бүрдэж дотоод хэрэгцээний цахилгаан, дулааны эрчим хүчний хэмжээг бууруулан, сэлбэг материал, болон ашиглалтын зардлыг хэмнэсэн.
- Хэмнэлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд дотоод хэрэгцээний цахилгаан, дулаан болон сэлбэн материал, мазут, соляркын хэрэглээг бууруулан, ашиглалтын зардлын хэмнэлт гаргасан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 679,132.4 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд нийт 149 мэдээллийг байршуулахаас 34,808.7 сая төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулах зөвлөмж хүргүүлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой

Тайлант онд 253.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Эсрэг осмосын мембрам”-ын бараа худалдан авах нээлттэй тендер шалгаруулалтын баримт бичигт “Хими цехийн 2025 онд захиалах их засварын тоноглолын техникийн тодорхойлолт”-д “Brand name: Nitto group company, Model Number: CPA-LD” гэж барааны худалдааны нэр, үйлдвэрлэгч, гарал үүслийг заасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т “Техникийн тодорхойлолтод тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайлан заахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендер шалгаруулалтын баримт бичгийн тодорхойлолтыг хуулийн дагуу бэлтгэж байх зөвлөмж хүргүүлээ.

2. Худалдан авах ажиллагаатай холбоотой

Тайлант онд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 389.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Тос, тосолгооны материал” нийлүүлэгчийг шалгаруулах тендерийн баримт бичгийн 19.1.3-т “Сүүлийн 2 жил буюу 2023, 2024 онуудын тус бүрийн аудитын дүгнэлтийг хавсарган ирүүлэх” гэж заасан боловч 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг ирүүлээгүй оролцогчийг шалгаруулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4.1-т “Энэ хуулийн 15, 16, 17 дугаар зүйлд заасан чадавхын болон туршлагын доод шаардлагыг хангасан байх”, 26.9-д “Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг нэгэн зэрэг хангасан тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ” гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг хангасан оролцогчийг гүйцэтгэгчээр шалгаруулж байх зөвлөмж өглөө.

3. Гэрээний сунгалттай холбоотой

Тусгай зориулалтын холхивч худалдах худалдан авах 24.9 сая төгрөгийн дүнтэй гэрээний хугацаа 2025 оны 11 дүгээр сарын 25-нд дууссаныг 2026 оны 01 дүгээр сарын 13-нд 30 хоногоор сунгах тухай нэмэлт гэрээг нөхөн байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасныг баримтлаагүй бол уг нэмэлт, өөрчлөлт илт хууль бус байна” гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хугацаа сунгах нэмэлт гэрээг гэрээний заалтад нийцүүлэн байгуулах зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн

холбогдох заалттай, худалдан авах ажиллагаа болон худалдан авах гэрээтэй холбоотой асуудлууд холбогдох хууль тогтоомжтой тус тус нийцээгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар компанийн 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.

Завсрын аудитаар нийт 842.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг асуудлын бүртгэлээр танилцуулж, баталгаажуулан жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нотлох баримтыг үндэслэн үнэлж, залруулагдаагүй алдаа, зөрчлийг аудитын тайланд тусгалаа.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 242.7 сая төгрөгийн 9 зөрчилд, 6.0 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 230.8 сая төгрөгийн 5 албан шаардлага, 5.9 сая төгрөгийн 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 2. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт */мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	6,029.6	2	6,029.6	100.0
Албан шаардлага	5	230,790.0	5	230,790.0	100.0
Зөвлөмж	2	5,926.7	2	5,926.7	100.0
Нийт дүн	9	242,746.3	9	242,746.3	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах асуудлуудыг авч үзэн, нарийвчилсан горим, сорил хэрэгжүүлж, шийдвэр гаргах эрх бүхий байгууллагуудад хандах нь зүйтэй байна. Үүнд:

- Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК нь жилд 2,667.3 мянган Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэж, Улаанбаатар хотын дулаан хангамжийн 29.2 хувийг ханган ажилладаг. Нийт дулаан түгээлтийн 90.8 хувь 2,421.0 мян Гкалыг Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-д усаар, 9.1 хувь буюу 242.0 мянган Гкал үйлдвэрийн уурыг 74 аж ахуй нэгж байгууллагад түгээн ажилладаг.
- Сүүлийн жилүүдэд нийслэл хотод барилгажилт эрчимтэй явагдаж, дулаан түгээлт жилд дунджаар 4.5 хувиар өсөж байгаа ба үүнийг дагаад Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн дулаан түгээлт дунджаар 3-5 хувийн өсөлттэй байна. Гэсэн хэдий ч Эрчим хүчний зохицуулах хорооноос үйлдвэрлэгч Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн дулааны тарифыг тогтоож өгдөг ба тус станцын ДЭХ-ний нийлүүлэлт нэмэгдэж байхад орлого 2022 оноос 12-36 хувиар буурсан байна.
- Дулааны эрчим хүчийг үйлдвэрлэх өөрийн дундаж өртөг 2025 онд 28,151.27 төгрөг боловч худалдах дундаж үнэ 4,578.03 төгрөгөөр борлуулсан нь нэгжээс 23,573.24 төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Дулааны эрчим хүчний тариф өртгөөсөө 6.1 дахин доогуур байгаа нь алдагдалтай ажиллах, мөнгөн урсгалын дутагдалд оруулах гол нөхцөлийг бүрдүүлж байна.
- Монгол Улсад дулааны эрчим хүчний үнэ тарифыг 2025 оны 5 дугаар сарын 16-наас эхлэн нэмэгдүүлэхээр төлөвлөж байсан боловч Засгийн газрын шийдвэрээр уг өөрчлөлтийг 2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл, 2025 оноос цахилгаан эрчим хүчний хэрэглэгчийн тарифыг индексжүүлэх ажлыг тус тус хойшлуулсан байна. Үүнтэй холбоотой нэг худалдан авагчийн алдагдал нэмэгдэж, 2026 онд улам нэмэгдэх хандлагатай байна. Нэг худалдан авагч дээр үүсэх алдагдал нэмэгдсэнтэй холбоотой тус станцын 2025 онд борлуулалтын орлого төвлөрүүлэлт 20 орчим тэрбум төгрөгөөр тасарсан байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа

Аудитаар нийт 28,368.3 сая төгрөгийн 3 алдаа² илэрсэнд 28,072.9 сая төгрөгийн 1 алдааг залруулах зөвлөмж хүргүүлж 295.4 сая төгрөгийн 2 алдааг залруулав.

Залруулсан алдаа:

1. Тус станцын эргэлтийн хөрөнгөнд 204.8 сая төгрөгийн дүнтэй, 2015 онд хийсэн, "БКЗ-220-100 маркийн зуухыг хурдасгасан буцламгай үет шаталтын технологи"-ийн ТЭЗҮ бүртгэсэн;
2. Тус станцын патент дансанд 90.6 сая төгрөгийн дүнтэй, "БКЗ-220-100 маркийн зуухыг хурдасгасан буцламгай үет шаталтын технологи"-д шилжүүлэх ажлын зураг төсвийг бүртгэж, бүрэн элэгдүүлсэн зэрэг нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-д Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой гэсэн заалттай нийцээгүй байсныг залруулав.

5.1.1 Зөвлөмж

Үндсэн хөрөнгөтэй холбоотой

Тайлант онд Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн байнгын ажиллагаатай тоног төхөөрөмжүүдэд засвар үйлчилгээ хийх зорилготой төлөвлөгөөт бүрэн зогсолтын хөтөлбөрийн дагуу 50 мВт-ын хүчин чадалтай турбогенератор №9-ийг зогсоох үед аюулаас хамгаалах төхөөрөмжийн клапан бүрэн хаагдаагүйгээс турбин эргэлт хэвийн хэмжээнээс их болж холхивчууд халсны улмаас гал гарч дэлбэрэлт болж, уг турбинийг дахин ашиглах боломжгүй томоохон хэмжээний эвдрэл гэмтэл үүссэн байна. Эрх бүхий байгууллагын шийдвэр эцэслэн гараагүйгээс 28,072.9 сая төгрөгийн төхөөрөмжийг данснаас хасаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.6 Бүх зардал" НББОУС-17 Үндсэн хөрөнгө стандартын заалттай нийцэхгүй байна.

Өгссөн зөвлөмж: Ослоос шалтгаалан утсан хөрөнгүүдийг эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн данснаас хасах эсэх асуудлыг судалж, хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авах.

Аудитаар нийт 243.3 сая төгрөгийн зөрчил³ илэрснээс, 3.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 172.6 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 67.2 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 28,316.2 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул зөрчлийн дүн болон шинж чанарын хувьд материаллаг гэж үзэн "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.2 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн санхүүгийн зөрчил

5.2.1 Төлбөрийн акт

1.Илрүүлэлт: Үйлдвэрчний эвлэлийн хорооны даргад 3.5 сая төгрөгийн мэргэшсэн инженерийн нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр олгосон 3.5 сая төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт хүргүүлэв.

5.2.2 Албан шаардлага

1.Илрүүлэлт: Тайлант онд Оптомастер ХХК-тай байгуулсан "ТГ№6 үндсэн өдөөгчийг тристорын өдөөгчөөр шинэчлэх ажлын гэрээ"-ний үүргийн биелэлт хангалтгүй, хугацаа хоцроосон харилцагчид 21.4 сая төгрөгийн гэрээний алданги тооцоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.5 Бүх орлого", "ТГ№6 үндсэн өдөөгчийг тристорын өдөөгчөөр шинэчлэх ажлын гэрээ"-ний 5.2-т " Гүйцэтгэгч нь ажлыг батлагдсан графикт хугацаанаас хэтрүүлбэл талууд харилцан тохиролцож гэрээний хугацааг сунгаж, нэмэлт өөрчлөлт оруулснаас бусад тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг Захиалагчид төлөх ба нийт алдангийн дүн нь гэрээний үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй байна. Алданги тооцож эхэлсэн тухайгаа Гүйцэтгэгч талд нь Захиалагч нь мэдэгдэнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний үүргийн биелэлтийг үнэлэн, хугацаа хоцроосон алдангийг нотлох баримтад үндэслэн, хуульд заасны дагуу тооцоогүй зөрчлийг таслан зогсоож, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан хүргүүллээ.

2.Илрүүлэлт: Тайлант онд 118.7 сая төгрөгийн авлага, 32.5 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.6 Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

5.2.3 Зөвлөмж

1. Үйл ажиллагааны зардалтай холбоотой

Бүх нийтийн амралтын өдөр буюу 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр ажиллаагүй 522 ажилтанд олгосон 3.4 сая төгрөгийн хоолны мөнгийг 12 дугаар сарын цалингаас суутгасан боловч 2025 оны 6 дугаар сарын 13-нд 154/А0150092 дугаар актын төлбөр болгон компаниас дахин төлж, үйл ажиллагааны бус зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалт болон УСННБОУС-24 Санхүүгийн тайлан дахь Төсвийн мэдээллийн толилуулга стандартын заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үйл ажиллагааны зардлыг бодитоор тайлагнах, анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх.

2. Авлагын данстай холбоотой

Он дамжсан, 2023-2024 онд үүссэн нэр бүхий 2 харилцагчаас авах 15.2 сая төгрөгийн эрчим хүчний авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Эрчим хүчний тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д "Эрчим хүчээр хангагч нь энэ хуулийн 25 дугаар зүйлд зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй", 29.1.7-д "Хэрэглэсэн эрчим хүчнийхээ төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй хэрэглэгчдийг эрчим хүчээр хангах гэрээг цуцлах, энэ хуулийн 33.1-д заасныг зөрчиж шугам сүлжээний хамгаалалтын зурваст буусан хэрэглэгчийг эрчим хүчээр хангахаас татгалзах", 30 дугаар зүйлийн 30.1-д "Хэрэглэгч

нь дараахь эрх, үүрэгтэй, 30.1.2-т "Эрчим хүчний төлбөрөө гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөх" гэсэн заалт болон УСННБОУС-24 Санхүүгийн тайлан дахь Төсвийн мэдээллийн толилуулга стандартын заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Он дамжсан авлагыг барагдуулж ажиллах.

3. Бараа материалын данстай холбоотой

Тус станцын техникийн склад №2-т бүртгэлтэй ашиглагдахгүй болсон 2 төрлийн 1229 ширхэг 4.6 сая төгрөгийн сэлбэг материал байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалт болон УСННБОУС-2 Бараа материал стандартын заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материал тавих хяналтыг сайжруулж, оновчтой төлөвлөж, бэлтгэж, зарцуулж байх

4. Бараа материалын данстай холбоотой

- 2014 онд бүтцийн өөрчлөлтөөр хүчилтөрөгчийн аж ахуй зогссоны улмаас компрессорт ашиглагдах 1,180 кг хэмжээтэй, 2016 онд олж бэлтгэсэн трансматорын тос ашиглагдахгүй, хөрөнгө үнэ цэнэгүй болсон;
- Бараа материалын дансанд бүртгэлтэй 9,948 кг хэмжээтэй, 2008 онд олж бэлтгэсэн, трансфоматорын тос чанар байдлаа алдаж өндөр хүчдэлийн туршилт, химийн шинжилгээгээр цаашид ашиглах боломжгүй нь тогтоогдсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалт болон УСННБОУС-2 Бараа материал стандартын заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материал тавих хяналтыг сайжруулж, тооллогын үр дүнг тухай бүрд шийдвэрлэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус станцын эргэлтийн хөрөнгөнд 204.8 сая төгрөгийн дүнтэй, 2015 онд хийгдсэн, "БКЗ-220-100 маркийн зуухыг хурдасгасан буцламтгай үет шаталтын технологи"-ийн ТЭЗҮ бүртгэсэн	1	204,765.2					1	204,765.2				
Тус станцын патент дансанд 90.6 сая төгрөгийн дүнтэй, "БКЗ-220-100 маркийн зуухыг хурдасгасан буцламтгай үет шаталтын технологи"-д шилжүүлэх ажлын зураг төсвийг бүртгэж, бүрэн элэгдүүлсэн	1	90,621.9					1	90,621.9				
Тайлант онд "Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн байнгын ажиллагаатай тоног төхөөрөмжүүдэд засвар үйлчилгээ хийх зорилготой төлөвлөгөөт бүрэн зогсолтын хөтөлбөрийн дагуу 50 мвт-ын хүчин чадалтай турбогенератор №9-ийг зогсоох үед аюулаас хамгаалах төхөөрөмжийн клапан бүрэн хаагдаагүйгээс турбин эргэлт хэвийн хэмжээнээс их болж холхивчүүд халсаны улмаас гал гаран дэлбэрэлт болж, уг турбинийг дахин ашиглах боломжгүй томоохон хэмжээний эвдрэл гэмтэл үүссэн байна. Эрх бүхий байгууллагуудын шийдвэр эцэслэн гараагүйгээс 28,072.9 сая төгрөгийн өртөгтэй тухайн төхөөрөмжийг данснаас хасаагүй байна.	1	28,072,889.7								1	28,072,889.7	
Алдааны дүн	3	28,368,276.8					2	295,387.1			1	28,072,889.7

/мянган төгрөгөөр/

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Үйлдвэрчний эвлэлийн хорооны даргад 3.5 сая төгрөгийн мэргэшсэн инженерийн нэмэгдэл олгосон байна.	1	3,510.1	1	3,510.1								
2	Тайлант онд Оптомастер ХХК-тай байгуулсан "ТГ№6 үндсэн өдөөгчийг тристорын өдөөгчөөр шинэчлэх ажлын гэрээ"-ний үүргийн биелэлт хангалтгүй, хугацаа хоцроосон харилцагчид 21.4 сая төгрөгийн гэрээний алданги тооцоогүй байна.	1	21,440.2			1	21,440.2						
3	Тайлант онд 118.7 сая төгрөгийн авлага, 32.5 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.	1	151,198.6			1	151,198.6						
4	Бүх нийтийн амралтын өдөр буюу 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр ажиллаагүй 522 ажилтанд олгосон 3.4 сая төгрөгийн хоолны мөнгийг 12 дугаар сарын цалингаас суутгасан боловч 2025 оны 6 дугаар сарын 13-нд 154/А0150092 дугаар актын төлбөр болгон компаниас дахин төлж, үйл ажиллагааны бус зардлаар тайлагнасан байна.	1	3,393.0					1	3,393.0				
5	Он дамжсан, 2023-2024 онд үүссэн нэр бүхий 2 харилцагчаас авах 15.2 сая төгрөгийн эрчим хүчний авлагыг барагдуулаагүй байна.	1	15,196.7					1	15,196.7				
6	Тус станцын техникийн склад №2-т бүртгэлтэй ашиглагдахгүй болсон 2 төрлийн 1229 ширхэг 4.6 сая төгрөгийн сэлбэг материал байна.	1	4,605.5					1	4,605.5				
7	1)2014 онд бүтцийн өөрчлөлтөөр хүчилтөрөгчийн аж ахуй зогссоны улмаас компрессорт ашиглагдах 1,180 кг хэмжээтэй, 2016 онд олж бэлтгэсэн трансматорын тос ашиглагдахгүй, хөрөнгө үнэ цэнэгүй болсон байна.	1	43,971.9					1	43,971.9				

Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2)Бараа материалын дансанд бүртгэлтэй 9,948 кг хэмжээтэй, 2008 онд олж бэлтгэсэн, трансформаторын тос чанар байдлаа алдаж өндөр хүчдэлийн туршилт, химийн шинжилгээгээр цаашид ашиглах боломжгүй нь тогтоогдсон байна.												
Нийт дүн	7	243,316.0	1	3,510.1	2	172,638.8	4	64,167.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
1	Шилэн дансны цахим системд 11.2 сая төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	1	11,216.6			1	11,216.6
Дүн		1	11,216.6			1	11,216.6
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
1	Тайлант онд 253.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Эсрэг осмосын мембрам"-ын бараа худалдан авах нээлттэй тендер шалгаруулалтын "Хими цехийн 2025 онд захиалах их засварын тоноглолын техникийн тодорхойлолт"-д "Brand name: Nitto group company, Model Number: CPA-LD" гэж барааны худалдааны нэр, үйлдвэрлэгч, гарал үүслийг заасан байна.	1	253,729.3			1	253,729.3
2	Тайлант онд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 389.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Тос, тосолгооны материал" нийлүүлэгчийг шалгаруулах тендерийн баримт бичгийн 19.1.3-т "Сүүлийн 2 жил буюу 2023, 2024 онуудын тус бүрийн аудитын дүгнэлтийг хавсарган ирүүлэх" гэж заасан боловч 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг ирүүлээгүй оролцогчийг шалгаруулсан байна.	1	389,286.5			1	389,286.5
3	Тусгай зориулалтын холхивч худалдах худалдан авах 24.9 сая төгрөгийн дүнтэй гэрээний хугацаа 2025 оны 11 дүгээр сарын 25-нд дууссаныг 2026 оны 01 дүгээр сарын 13-нд 30 хоногоор сунгах тухай нэмэлт гэрээг нөхөн байгуулсан байна.	1	24,900.0			1	24,900.0
Дүн		3	667,915.8			3	667,915.8
Нийт дүн		4	679,132.4			4	679,132.4



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 696/А0150092

Улаанбаатар хот

САГ-2026/27/НА -СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эцэст 118,679,012.76 /Нэг зуун арван найман сая зургаан далан есөн мянга арван хоёр төгрөг далан зургаан мөнгө/-ний авлага, 32,519,548.98 /Гучин хоёр сая таван зуун арван есөн мянга таван зуун дөчин найман төгрөг ерэн найман мөнгө/-ний өглөг, нийт 151,198,561.74 /Нэг зуун тавин нэгэн сая нэг зуун ерэн найман мянга таван зуун жаран нэгэн төгрөг далан дөрвөн мөнгө/-ний авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
3. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Сандуйжав/, нягтлан бодогч /П.Пүрэвсүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
А.МӨНХЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 695/A0150092

Улаанбаатар хот

САГ-2026/27/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Оптомастер ХХК-тай байгуулсан "ТГ№6 үндсэн өдөөгчийг тристорын өдөөгчөөр шинэчлэх ажлын гэрээ"-ний үүргийн биелэлт хангалтгүй, хугацаа хоцроосон харилцагчийн 21,440,197.36 /Хорин нэгэн сая дөрвөн зуун дөчин мянга нэг зуун ерэн долоон төгрөг гучин зургаан мөнгө/-ний гэрээний алданги тооцоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" 14.4.5-д "Бүх орлого", "ТГ№6 үндсэн өдөөгчийг тристорын өдөөгчөөр шинэчлэх ажлын гэрээ"-ний 5.2-т "Гүйцэтгэгч нь ажлыг батлагдсан график хугацаанаас хэтрүүлбэл талууд харилцан тохиролцож гэрээний хугацааг сунгаж, нэмэлт өөрчлөлт оруулснаас бусад тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг Захиалагчид төлөх ба нийт алдангийн дүн нь гэрээний үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй байна. Алданги тооцож эхэлсэн тухайгаа Гүйцэтгэгч талд нь Захиалагч нь мэдэгдэнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "Байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний үүргийн биелэлтийг үнэлэн, хугацаа хоцроосон алдангийг нотлох баримтад үндэслэн, хуульд заасны дагуу тооцоогүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Сандуйжав/, нягтлан бодогч /П.Пүрэвсүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
А.МӨНХЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 159/АДИ50092

Улаанбаатар хот

САГ-2026/27/НА - СТА - ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйлдвэрчний эвлэлийн хорооны даргад 3,510,147.67 /Гурван сая таван зуун арван мянга нэг зуун дөчин долоон төгрөг жаран долоон мөнгө/-ний мэргэшсэн инженерийн нэмэгдлийг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3 "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр олгосон 3,510,147.67 /Гурван сая таван зуун арван мянга нэг зуун дөчин долоон төгрөг жаран долоон мөнгө/-ийг нягтлан бодогч /П.Пүрэвсүрэн/-ээр төлүүлж, Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Сандуйжав/-т даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

(Handwritten signatures)

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
А.МӨНХЦЭЦЭГ

